



## ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР УНШИЖ, БИЧИХ ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ НЭГЭН САНАЛ

С.Гандэлгэр  
МУБИС-Багшийн сургууль, багш, магистр

Холбоо барих зохиогч: Gandelger.s@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2023.11.11

Хянагдсан: 2023.12.12

Зөвшөөрсөн: 2023.12.25

### Хураангуй

Монгол хэлний тухай хууль, Үндэсний бичгийн хөтөлбөрүүд, МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг гэх мэт эрх зүйн бичиг баримтуудад 2025 оноос эхлэн хос бичигтэн болох заалт, зорилгууд туссан байдаг. Бүх шатны болосролын байгууллагын сургалтын хөтөлбөрт Үндэсний бичгийн цаг нэмэгдэж, агуулгын өөрчлөлт гарч буй. Мөн албан байгууллага, аж ахуй нэгж, ард иргэд сайн дураараа Үндэсний бичгээ сурах хөдөлгөөн эрчимжиж байна.

Үүн лугаа чиглэж аливаа хүн ямар нэг үйлийг хийж гүйцэтгэхдээ урьдаар хялбар дөхөм аргад шүтэж, явал үүнийг амархан хийх вэ? Яаж хялбархан сурах вэ? хэмээн үргэлжид эрэлхийлж байдаг. Тус хэрэгцээнээс үүдэн Кирилл бичгээр эрдэм амласан хүмүүст Үндэсний бичгийг хэрхэн хялбар дөхөм байдлаар заах вэ? гэсэн санаанд тулгуурлаж, нэн тэргүүнд толь бичгээс дуудлага, бичлэг адил үгсийг ялган, сурах сургах үйлдээ ашиглавал үр дүн гарна хэмээн сэтгэж тус өгүүллийг бичлээ.

Учир нь Үндэсний бичгийн хэлний бичгийн хэлний үгс орчин цагийн хэл аялгуунаас нэлээд зөрүүтэй болсон байдаг.

### Түлхүүр үг

Үндэсний бичиг, заах арга, уламжлал шинэлчлэл

### Удиртгал

Монголчуудын бичиг соёлын нандин өв, хэдэн зуун жилийн түүхийн улаач болсон Үндэсний бичиг нь дэлхийн бүх бичиг үсгийн түгээмэл шинжийг хадгалж чадсан / зургийн бичиг буюу pictography, утгын бичиг буюу ideography, үеийн бичиг буюу syllabography, авианы бичиг буюу phonography/ юм. Хэрэглэж эхэлсэн хугацааг наанадаж 1000 жил хэмээн үзвэл, хэлний хөгжлийн жам ёсоор бичгийн болон ярианы хэлний зөрүүтэй болсон байдаг. Гэвч шинжлэх ухааны үндэслэл бүхий хэл зүйтэй, зөв бичгийн тогтсон дүрэмтэй, заан сургаж ирсэн баялаг уламжлалтай тул

сурч эзэмшихэд тийм ч хүчир биш.

Өмнөх цаг үед бүх нийтээр бичиг үсэгтэн болох зорилгогүй байсан учраас бичиг үсэгт тайлагдсан цөөн хүмүүс бичигт сургах ажлыг өөр өөрийн арга, туршлагаар заан сургадаг байжээ. Үндэсний бичиг заах аргын баялаг түүх бол олон зууны турш монгол нутагт үе үеийн мэргэд, номын багш нарын хичээл зүтгэлийн үр дүнд бий болсон туршлага, сургалтын явцад бүрэлдэн тогтсон арга барилын цогц юм.

Заан сургалтын арга нь хэдий тогтворжиж, уламжлалт сургалтын хэв маягийг орчин үетэй хослуулж, материал хэрэглэгдэхүүний хувьд дэвшин буй авч, үр дүн төдий л санаан дураар биш буй нь заах арга, хэрэглэгдэхүүний шинэчлэлтийг биднээс шаардаж байна. Тус өгүүлэлд үе үеийн бичгийн мэргэдийн заах аргын уламжлалд дулдуйдаж, өөрийн туршиж, хэрэгжүүлж буй аргаа хуваалцахыг зорилоо.

## Үндсэн хэсэг

Үндэсний бичгийн заах аргын тухай онолын ном судар, гарын авлага болохуйц материал бидний үед уламжлагдаагүй ч, заах аргын уламжлалыг бичиг үсэг хэрэглэж эхэлсэн цаг үетэй холбон тайлбарлах нь зүйн хэрэг. Үндэсний бичгээ сурах, сургахад хэрэглэж байсан 20 орчим хэл зүйн бичиг, 40 орчим цагаан толгойг Академич Б.Ринчен “Монгол хэлний зүй” /Тэргүүн боть/ номдоо бүртгэн жагсааж, ном тус бүрийн тухай товч тайлбар бичсэн байдаг. Эдгээр цагаан толгойн бүтэц, бүрэлдвэрээс үзвэл, заах арга зүйч багш Г.Лхаахүү “Монгол бичгийг:

- Цагаан толгойн уг дүрс
- Гурван хувирал
- Дэвсгэр үсэг
- Галиг үсэг гэсэн 4 үе шаттайгаар зааж байсан нь манай өвөг дээдсээс уламжилж ирсэн арга мөн гэж үзэж болно” [2:6-7] дүгнэн бичжээ.

Хэл бичиг заах арга зүйч С.Шарав нар “Дунд сургуульд монгол хэл заах арга” номдоо “Хэлний мэдлэгийг заан сургахад тайлбарлан ярих, харилцан ярилцах, задлан шинжлэлийн зэрэг сургалтын аргууд байх төдийгүй судалгааны ба сургалтын бүх арга нь хүний танин мэдэх сэтгэлгээний индукц, дедукц, анализ, синтез, аналогийн аргуудад түшиглэн явагддаг байна” [7:27-28] хэмээжээ.

Үндэсний бичигт анх суралцаж буй хүмүүст нэн тэргүүнд цагаан толгойн үсгүүдийг:

- Үндсэн зурлага
- Эгшиг үсэг
- Дэвсгэр үсэг /зөөлөн, хатуу/
- Үл дэвсгэрлэх үсэг
- Галиг үсэг гэсэн тогтолцоотойгоор /ижил төсөөтэй шинжээр нь/ багцлан таниулбал нүдлэн тогтооход

дөхөмтэй. Энэ талаар эрдэмтэн Д.Баттогтох “Монгол бичгийн цагаан толгой бол монгол хэлний бүх авиаг цөөн хэдэн зурлага, ялгах тэмдэг тэргүүтнийг хэрэглэж ялгасан өвөрмөц үсэг зүйтэй бичиг бөгөөд нэг үсгийн /графем/ олон хувилбар /аллограф/-ыг ажиглуулж, дүр байдлыг үзүүлж заах нь сурагчдын ажиглах үйл, жишин харьцуулж, ялгах оюуны үйл, дүрслэх, загварчлах сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлэхээс гадна үсгээ бөөнтгөн таниулах боломж нь цагаан толгойг богино хугацаанд эрчимтэй зааж сургах нэг чухал нөхцөл болно” [1:166] хэмээжээ.

Сурагчдыг уншуулж, бичүүлж сургах ажил нь эгшиг үсгийг таниулахаас эхлэн тодорхой систем үе шаттай явагдах маш нарийн үйл ажиллагаа байдаг. Үндэсний бичгээр үсэг холбуулан уншуулж, бичүүлэх дэс дараа, сургах арга нь өвөрмөц онцлогтой байсныг бидэнд уламжлагдан ирсэн цагаан толгойнуудаас мэдэж болно. Тухайлбал, Дэлэгжунайн зохиосон “Монгол үсгийн гол ёсыг тодотгогч толь” хэмээх цагаан толгойд үсэг хурж нэр болохыг үзүүлэхдээ:

- Хоёр амьт үсэг хурсан - Mb rI, Ne \*T, Ho sO,
- Амьт амьгүй үсэг хурсан - Ge \*, Ge &, Ji &, bR
- 3 үсэг хурж нэр болсон - Ni kE a, Ho ye \*, Ji ge sO
- 4 үсэг хурж нэр болсон - fe B ri &, Go r bIa, Fr de nI гэх мэтээр 13 үсэг хурж нэр болсныг жишээгээр батлан гаргасан нь уншуулж, бичүүлэх үе шатыг тогтоосон хэрэг юм.

Уламжлалт хэл зүйн бичгүүдээс харахад үеийн аргыг голчлон бусад арга /үсгийн, бүтэн үгийн гэх мэт/-ыг дагалдуулах маягтайгаар заадаг байжээ. Үеийн аргыг голчилдог шалтгааныг Өвөрмонголын эрдэмтэн Сэцэнцогт “Монгол үсгийн язгуурын толь дахь 30000 үгийн үе бүтцэд тооцоо хийн задгай үе задгай үетэйгээ холбогдож бүтэн үг, бүх үгийн 70%, задгай ба битүү үе холбогдсон үг 20%, битүү үе битүү үетэйгээ холбогдсон үг 10%-ийг тус тус эзэлж байна. Үүнээс дүгнэвэл монгол хэлний үгийн язгуур нь заавал үеэр бүтдэг бөгөөд судалгааны талаас үзвэл голдуу задгай үеэс бүтсэн байна” [1:32] хэмээн судлаач, эрдэмтэн Д.Баттогтох өөрийн бүтээлдээ эшилжээ.

Дээрх судалгаанаас харахад үе холбон заах арга нь Үндэсний бичигт гол арга болохыг нутгалж байна. Үе бол авиа үсгээ бодвол үг болох, утга илтгэхэд нэг шат ойртсон хэлний завсрын нэгж түвшин болохоор хүний харааны сэрэлд буух, сонсох ба хэлэхэд тодорхой мэдэгдэм бөгөөд тодорхойгоос хийсвэрт, хийсвэрээс тодорхойд шилжих сэтгэхүйн хуульд нийцтэй болно. Нөгөөтэйгүүр үгийг хэлэхэд үг нь амьсгалын түрэлтээр тодорхой хэсгүүдэд хуваагддаг бөгөөд энэхүү хуваагдан хэлэгдэж буй хэсэг бол үе юм. Үе нь үгийг бүтээж уншиж, бичих үндсэн нэгж болдог.

Мөн С.Шагж “Монгол бичигт сургах дөт зам” номынхоо оршилд “Манай монгол хэлний бичгийг эгшиггүй үсэг болтол салгаж зохихгүйг, европын хэл мэт дан ганц амьгүй үсэг үг болсон нь ер үгүй ба эгшиггүй үсгээр толгойлсон жинхэнэ монгол үг огт үгүй” [6:3] хэмээн бичжээ. Үүнээс үзэхэд монгол бичиг заах аргын хамгийн сонгомол арга нь үеийн арга гэдгийг баталж байна.

Ганц үет утгат үг уншуулах нь хамгийн хялбар, богино үг байдаг бөгөөд ярианы хэлтэй яг таарах тул үсгээ л таньж байвал уншихад төвөггүй. Уламжлалт заах аргад ийм үсгийг “Цагаан үг” /Цагаан гэдэг үг амар, хялбар эхлэл гэсэн утга илтгэнэ/ хэмээдэг. Үндэсний бичгийн хэлний үгс болоод орчин цагийн монгол хэлний үсгийн хооронд дуудлага, бичлэгийн зөрүү нэлээд байдгаас шалтгаалж, монгол бичиг сурах нь хүнд хүчир мэт сэтгэхүй төрдөг. Гэтэл дуудлага хийгээд бичлэг тохирдог үгс нэлээдгүй байна.

## Судалгааны үр дүн

Бид Ш.Чоймаа нарын эмхэтгэн найруулсан “Монгол хэлний хадмал толь” дахь 50000 орчим үгээс 4000 гаруй үг нь дуудлага, бичлэг тохирч буйг ажиглан, бүртгэн жагсаасан. Үүнээс орчин цагийн монгол хэлнээ идэвхтэй хэрэглээнд буй утга таних үг 3000 гаруй байгааг ялган, үг тус бүрийн үеийн тоог харгалзан хөнгөнөөс хүнд рүү шаталсан /иерарх/ тогтолцоогоор ангилан, сургалтад ашигласан. Кирилл бичгийн суурь мэдлэгт тулгуурлан заах энэ арга суралцагчдад богино хугацаанд Үндэсний бичгийн анхан шатны мэдлэгийг өгч болохоор байгааг үр дүн нь харуулсан. Ажиглалтын дүнд суралцагчид хүнд хүчир хэмээх сэтгэхүйгээс ангижирсан төдийгүй цаашид сурах сэдэл төрүүлж чадсан нь тус аргын үр дүнг баталж байна. Үндэсний бичгээр уншиж, бичих нь хоорондоо харилцан уялдсан, нягт шүтэлцээтэй үйл юм. Нэн тэргүүнд унших үйлийг чиглүүлж улмаар бичих үйлийг дагалдуулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл цагаан толгойн үсэг таниулах явцдаа дараах маягаар уншиж, бичих үйлийг хамтад нь үзээд явбал зүйтэй мэт. Тухайлбал,

### 1. Утгат үе буюу үг унших, бичих:

- Дан эгшиг үсгээс бүтсэн үгс - fel /ay/, fol /oy/, fol /uy/, foil /üy/
- Задгай болон битүү үеэс бүтсэн 1 үет үгс - foa /on/, fe<sup>^</sup> /am/, F<sup>^</sup> /em/, fi<sup>^</sup> /im/, la /la/, fo<sup>^</sup> /ol/, MeI /may/, LeI /lay/, M<sup>^</sup> /mal/, Ne<sup>^</sup> /nam/, No<sup>^</sup> /nom/, Moia /m<sup>o</sup>n/, feeit /ang/, Feit /eng/, Seeit /sang/, fe\$ /ab/, F\$ /eb/, fo\$ /ob/, Foi\$ /öb/, F\_ /es/, fo( /uy/, bIt /ba/, bA /bi/, bEl /bay/, Sol /soy/, Gel /γay/, GoO /γuu/, bB /bal/, BI /buy/, BO /buu/ BO /büü/, B<sup>^</sup> /bol/, bE( /bay/, MoI\* /m<sup>o</sup>r/, DeI /day/, Ne\* /nar/, Se\* /sar/, So\* /sur/, SoI\* /sür/, Se<sup>^</sup> /sal/, Se<sup>^</sup> /sam/, Ge<sup>^</sup> /γam/, Gea /γan/, Ge<sup>^</sup> /γal/, Ge\* /γar/, B( /boγ/, B( /buγ/, kE<sup>^</sup> /gem/, kE<sup>^</sup> /ger/, Kia /gün/, Ki<sup>^</sup> /güm/, Deoa /dad/, FdA /ed/, DedA /ded/, BdA /bud/, foaa /od/, Jooa /jud/, Kieit /güng/, Deeit /dang/, Geeit /γang/, Fit /eg/, foiit /ög/, Seit /seg/, De\_ /das/, Ni\_ /nis/, B\_ /bos/, Bi\_ /büs/, Kil /küy/, Del /tay/, CI /çi/, Da /ta/, Ja /ja/, Hel /qay/, Doil /tüy/, Jel /jay/, Joil /jüy/, Del /tay/, He\$ /qab/, kE\$ /keb/, Ho\$ /qob/, Ki\$ /k<sup>o</sup>b/, He<sup>^</sup> /qam/, kE<sup>^</sup> /kem/, Ho<sup>^</sup> /qom/, Ki<sup>^</sup> /k<sup>o</sup>m/, Hea /qan/, kA /ken/, Hoa /qun/, Ho\* /qur/, foI<sup>^</sup> /öl/, Ki<sup>^</sup> /k<sup>o</sup>l/, Do\$ /tob/, DoI\$ /t<sup>o</sup>b/, Do<sup>^</sup> /tul/, DoI<sup>^</sup> /t<sup>o</sup>l/, DoI\* /tür/, Si<sup>^</sup> /sil/, Je\$ /jab/, JoI\$ /j<sup>o</sup>b/, Je<sup>^</sup> /jam/, Ji<sup>^</sup> /jil/, Jo<sup>^</sup> /jol/, Joa /jon/, He( /qay/, Ho( /qoy/, Ce( /čaγ/, Co( /čoy/, Co( /čuy/, Ceoa /čad/, Coi<sup>^</sup> /č<sup>o</sup>m/, Ceit /čeg/, Ciit /čig/, Ce\* /čar/, Joieit /j<sup>o</sup>ng/, Soieit /s<sup>o</sup>ng/, Kiit /k<sup>o</sup>g/, Joieit /j<sup>o</sup>g/, Soieit /s<sup>u</sup>g/, Deit /teg/, Siit /sig/, Doieit /tüg/, De\_ /tas/, De\_ /tes/ ...

### 2. Хоёр үетэй үг унших, бичих

- Задгай+задгай - felJoO /ayijuu/, felSol /ayisuy/, feml /amuy/, ferel /aray/, feeoI /aquy/, fegoO /ayuu/, bElcel /bayičay/, bEl /balay/, ByO /buyu/, GeeeI /γaqay/, Godol /γodoy/, Golil /γoliy-, GooeeI /γouquy-, Dedel /daday-, DeUdel /dayitay/, Delel /dalay/, Delil /daliy/, Delio /daliu/, Derel /danay-, Derel /daray-, Derol /daruy/, DeroO /daruu/, Dodil /dodiy-, Doyil /doyiy-, Dolil /doliy-, DoliO /doliu-, Dorol /doruy/, Jilil /jiliy-, Jimil /jimiyy-, Jiril - /jiriy/, Jojil /jojiy/ ...
- Задгай+битүү - fedi\_ /adis/, Fede\* /adar/, Feji( /ajiy/, feji<sup>^</sup> /ajil/, Fejia /ajin/, felne( /ayimay/, felJre( /ayiray/, Fema /aman/, Feme\* /amar/, Femia /amin/, Fere<sup>^</sup> /aral/, Feri( /ari

Ү/, Fede( /aday/, feDo^ /atom/, Feeee\* /aqar/, Feeee\_ /aqas/, Fesi( /ašiҮ/, Fejo& /ayul/, bIge\_ /baҮas/, bIki\* /bakir/, bIde( /baday/, bIdeU\* /badayir-, bIdea /badan/, bIde\* /badar/, bIUge& /bayiҮal/, bIUde& /bayidal/...

- Битүү+задгай - felcel /alčay/, Feldel /altay/, Feeghel /angҮay/, fergel /arҮay / bleesel /bay say-, bIedel /banday-, bIrijil /barjiҮy-, BIkiA /bolki/, BIco0 /bolčuu/, BnBI -/bombuy/, Bedol /bondoy-, BIco0 /bulčuu/, Bedel /bunday-, Gemdel /Үamtay/, Dersel /darsay-, Dereeel /darqay-, DonBI /dombuy-, DorkuA /dorgi/, Demel /demtey-, JenbIt /jamba/, Lebsel /Iabsay-, Leeedel /Iayday-/ ...
- Битүү+битүү - Febce& /abčal/, Feeele( /ayIay/, feUlse( /ayilsay/, feUlcia /ayilčin/, Felbua /albin/, FembIa /amban/, Felde\* /aldar/, Felde\_ /aldas/, Feldea /altan/, Fense\_ /almas/, Feeghe& /angҮal/, Feeghe\* /angҮar/, Feekge\_ /angҮas/, Feekir\* /anggir/, Fereee( /arqay/, feDle\_ /atlas/, bIci( /balčiҮ/, bIci\* /balčir/, bIbI\* /bambar/, bIbI\_ /bambas-, bIdea /bandan/, bIjea /banjan/, bIrd^ /bardam/, bIrd( /bartay/, bIrcеoa /barčad/, bIrcia /barčin/, BIdo( /boldu Ү/ ...

### 3. Гурван үетэй үг унших, бичих

- Задгай+задгай - Felima /aliman/, Fekum( /akimay/, bIgeloo\* /baҮaluur/, bIgedel /baҮatay/, bIgeeeea /baҮaqan/, bIbena /banana/, bIrim& /barimal/ ...
- Задгай+битүү - feleedel /alayday/, Fenede^ /amindem/, Fenerееea /amarqan/, Feegereeel /ang Үarqay/, Fenireeea /anirqan/, Ferejee& /aranjal/, Fereesia /aranҮin/, Fejoldea /ayultan/, bIereeel /balarqay/, bIril) t /barily-a/ ...
- Битүү+битүү - Felderdea /aldartan/, Feldeede& /aldaydal/, Feldersi& /aldaršil/, bIcireeeea /balčirqan/, bErdemne& /bardamnal/ ...
- Битүү+задгай - Feegere( /angҮaray/, Feekule& /anggilal/, Fergeme( /arҮamay/, fergedel /arҮ atay/, Fereede( /aranday/, bIbIge\* /balbaҮar/, bIbIge\* /bambaҮar/, bIedida /bandida/ ...

### 4. Дөрөв болон түүнээс дээш үетэй үг унших, бичих

feldersi&kgol /aldaršingҮuy/, bIereeeUsi& /balarqayišil/, Feniцireee( /aminčirqay/, Fnjeksilidel /emjegšiltey/, Zenbigena /šambiyana/, Zelbigena /šalbayana-, CicirkIina /čičirgene-, Helbigena /qalbayana-, FoinekIidel /ünegeldey/, Focirleehgol /učirlangҮuy/, DerbIgecia /tarba Үačin/, DebulgenaT /tabilayana/, SembkirkIa /sembegerken/, Normigena /nurmayana-, Merktjildea /mergejilten/, Jelbigena /jalbiyana-, Geceeedel /ҮačiҮdaltay/, GeUeeensiweedel /ҮayiqamšiҮtay/, bIereeeel /baqarqaltay/ ... гэх мэт.

Энэ мэтээр үе, үг, холбоо үг уншаад сурсан цагт өгүүлбэр, эх унших үйлийг удирдан чиглүүлэхэд сургалтаа чиглүүлбэл зохино. Үе холбон заах арга нь Үндэсний бичигт хамгийн тохиромжтой арга бөгөөд анхлан суралцаж буй хүмүүст цагаан толгойн үеийн хүрдийг нүдлэн тогтоолгох хэрэгтэй. Үсгүүд хурж үе бүтэх, үеүд хурж үг бүтэх, үгс хурж холбоо үг бүтэх, холбоо үгс хурж өгүүлбэр бүтэх, өгүүлбэрүүд хурж эх бүтэх жамтай. Хэлний эдгээр нэгжүүд нь багтах, багтаах харьцаанд оршиж байдаг.

## Дүгнэлт

Монгол үсэг заах уламжлалт арга зүй нь монгол хэлний бүтэц, үсэг зүй, монгол хүний сэтгэцийн онцлог, ардын сурган хүмүүжүүлэх зүйтэй нь нягт шүтэн барилдаж, монгол соёлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болтлоо хөгжсөн тул уламжлалт заах аргын бэлэн арга барилуудаас шууд авч хэрэглүүштэй зүйл багагүй байгаа ч багш бүрийн бүтээлч эрэл нэн чухал.

2012 онд УИХ-ын чуулганаар “Монгол хэлний хууль”-ийг баталж, хэрэгжүүлэх болсонтой холбоотойгоор Үндэсний бичгээ сурах хүмүүсийн эрмэлзэл нэмэгдэж, албан байгууллагууд ажилчдадаа сургалт зохион байгуулах, хамтран сурах хөдөлгөөн эрчимжиж байна. Иймд хүмүүсийн кирилл бичгийн суурь мэдлэг, чадварт нь тулгуурлаж, бичгийн болон ярианы хэлэнд тохирч буй үгсийг нэн тэргүүнд заан, улмаар хөнгөнөөс хүнд рүү шаталсан тогтолцоотойгоор дуудлага, бичлэг зөрүүтэй үгсийг уншиж бичүүлэх маягаар хичээлийн үйл явцаа удирдан чиглүүлбэл үр дүнтэй байна.

Цагаан толгойн үсгүүдийн ижил төсөөтэй шинжүүдэд тулгуурлан багцалж, уншиж бичих үйл явцыг уламжлалт үеийн аргыг голдлого болгон бусад арга /үсгийн арга, бүтэн үгийн арга гэх мэт /-ыг дагавар маягаар заан таниулах нь чухал. Тухайлбал, Ой тогтоолтын аргуудаас ашиглан уламжлалт бичлэгтэй үг, дүрс ялган бичих үгсийг бүтэн үгийн аргаар нүдлэн тогтоох гэх мэт.

Монгол бичгийн сургалтад уламжлал, шинэчлэлийг хослуулж, арга билгийн шүтэлцээ лугаа уялдуулан, орчин цагийн сургалтын шинэлэг аргуудыг цахим технологитой холбон сургалтаа зохион байгуулбал хэрэгцээ бидний өмнө тулгарч байна.

Жич, дээрх арга нь богино хугацаанд, уншиж бичүүлэх зөв суурь эзэмшүүлэхэд л чиглэсэн болно.

## Ном зүй

Баттогтох, Д. (1995), Монгол бичиг заах аргын уламжлал шинэчлэл, УБ.

Лхаахүү, Г. (1996), Монгол бичиг заах арга зүй, УБ.

Нацагдорж Ц. (1996), Монгол бичиг заах арга зүйн зөвлөмж, УБ

Ринчен, Б. (2012), Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган, 5-р боть, Монгол бичгийн хэлний зүй, Тэргүүн дэвтэр. УБ.

Чойжилсүрэн, Д. (1978), Монгол хуучин бичгийн цагаан толгой, зөв бичих дүрэм. УБ:

Чоймаа, Ш нар. (2012), Монгол хэлний хадмал толь, УБ. Соёмбо принтинг

Шагж, С. (1991), Монгол бичиг сургах дөт зам, УБ.

Шарав, С нар. (1988), Дунд сургуульд монгол хэл заах арга. УБ.

## A PROPOSAL TO DEVELOP THE ABILITY TO READ AND WRITE IN MONGOLIAN NATIONAL SCRIPT

Gandelger.S

Master, Lecturer, Teachers school, MNUE

Corresponding author: Gandelger.s@msue.edu.mn 

### **Abstract**

Legal documents such as the Law on the Mongolian Language, National Literacy Programs, and the Presidential Decree of Mongolia contain provisions and goals for bilingualism starting from 2025. National writing hours are increasing and content changes are taking place in the curriculum of all levels of educational institutions. Also, the movement of voluntary learning of the national script by official organizations, enterprises, and citizens is intensifying.

Aiming at this, when a person performs an action, he worships in an easy and convenient way, and how can he do it easily? How to learn easily? Is always looking for. How to teach the National Script in an easy way to those who have promised to learn Cyrillic due to the need? Based on this idea, I wrote this article thinking that first of all, it would be effective to distinguish pronunciation and recording words from the dictionary and use them in teaching and learning.

Because the words of the written language of the National Written Language are quite different from the dialect of the modern language.

### **Keywords**

Reform of Mongolian national script, teaching methods and traditions

---